

Харсан бол заавал мэдээл

2025 оны 1 сар



1-р зураг. Хоёр ижил дамар, хоолой

Аудитын баг шинээр ашиглалтад орсон ачих/буулгах станцад ажиллаж байсан. Багийн гишүүн, хоёр ижил дамар, хоолой, ижилхэн өнгөтэй хоолойтой, ижилхэн холболттой байгааг олж харсан. Нэг нь даралтат хий, нөгөө нь азотын хий гэсэн шошготой байсан. Багийн гишүүн хоолойнуудыг яаж ашигладгийг асуусан. Даралтат хийн хоолойг хийн цохилтот багаж ажиллуулахад, азотын хийн хоолойг танк суллахад ашигладаг.

Аудитын багийн гишүүн энэ хоёр хоолойг сольж ашигласан тохиолдолд инертийн хийгээр даралт үүсгэж суллах ёстой танкд инертийн бус хийгээр даралт үүсгэж, улмаар гал гарах эрсдэлтэйг хэлсэн. Зураг төсөл боловсруулах, ажиллуулахын өмнөх аюулгүй ажиллагааны шалгалт хийх үед энэ эрсдэлийг хэн ч олж анзаараагүй байсан. Даралтат хийн хоолойд цоож, пайз зүүж, өөрчлөлтийн менежментийн дагуу шалгаж баталгаажуулж дуусах хүртэл ашиглахыг хориглосон. Өөр аюул ч бас тохиолдож болох байсан. Хэн нэгэн азотын хийн хоолойг хийн цохилтот багаж руу холбосон бол хүчилтөрөгчийн дутагдалтай орчин үүсэж ажилтан ухаан алдах магадлалтай байсан.

Энэ бол энгийн асуулт асууснаар хоёр төрлийн ноцтой осол гарахаас амжилттай сэргийлж чадсан жишээ болж байна. Мөн ямар нэгэн зүйл буруу байгааг анзаарсан бол үгээ хэлж байх шаардлагатайг харуулж байна.

Та мэдэх үү?

- Сулхан шинж тэмдэг ямар нэгэн зүйл буруу байгааг илэрхийлж байж мэднэ. 1-р зурагт хоёр ижил дамар, хоолойг сольж ашиглах боломжтой байгаа нь сулхан шинж тэмдэг болж байна.
- Тоног төхөөрөмж нэг л өөр дуу чимээ гаргаж, чичиргээ үүсгэж байвал ямар нэгэн зүйл буруу, анхаарал хандуулах шаардлагатай байгааг илэрхийлэх сулхан шинж тэмдэг болно.
- Сулхан шинж тэмдэг аажим томорсоор хүчтэй шинж тэмдэг болж, тоног төхөөрөмж эвдэрсэн, тос гоожсон тохиолдолд анзааралгүй өнгөрөх аргагүй болно.
- Олон том осол сулхан шинж тэмдэг, анхаарал татах дохио өгч байгааг анзаараагүйгээс болсон байдаг. Осол болсны дараа шинж тэмдэг ойлгомжтой болдог.
- Сулхан шинж тэмдгийн талаар бусдадаа мэдэгдэж бай. Чухал зүйл биш байх гэж найдаж орхисноос шалгаж үзээд хэвийн байгааг нь тогтоосон нь өлзийтэй.
- Хүмүүс ялгааг олж анзаарч байдаг нь сайн хэрэг. Гэхдээ хариуцсан хүмүүс нь олж мэдэж, засаж залруулах арга хэмжээ авахгүй бол аюул оршсоор байна.
- Муу боловсруулсан журам ч бас сулхан шинж тэмдэг байж мэднэ. Туршлагатай операторуудын хувьд зүгээр байж болох ч шинэ ажилчид буруу ойлгож мэднэ.

Та юу хийх ёстой вэ?

- Ямар нэгэн зүйл зөв биш санагдвал тухайн хэсгийг хариуцсан ахлах ажилтанд мэдэгд. Тэд зохих нөөцийг ашиглан, нөхцөл байдлыг шалгаж, шаардлагатай бол засварлана.
- Өмнө нь үзлэг шалгалт хийснээс хойш өөрчлөгдсөн зүйл байгаа эсэхэд анхаар. Анзаарч мэдсэн зүйлээ асууж тодруул.
- Эргэлзээтэй журмуудыг зас. Зураг, диаграмм нэмж сайжруулах хэрэгтэй санагдвал ахлах ажилтандаа хэл.
- Талбай дээр ажиллаж байхдаа тодорхой асуудлыг эрж хайж бай. Цахилгааны самбар онгорхой байх, дээжийн савыг таглаагүй байх, хэмжүүр ажиллахгүй байх зэрэг нь засаж залруулах, болзошгүй осол гарахаас сэргийлэх нөхцөл юм.

Ямар нэгэн зүйл буруу санагдвал - АСУУ! Та хүний амь насыг аварч ч мэднэ.